



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 2/81

Арвайхээр

Арвайхээр сумын сууц өмчлөгчдийн холбооны орон сууцны барилгын ариутгал, халдваргүйтгэлд хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн Засаг даргын 2020 оны А/502 дугаар захирамж, сумын Засаг даргын 2020 оны А/201 дүгээр захирамжийн хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус (Covid-19)-ийн цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах, халдвар гарсан бүсийг ариутгах, цэвэрлэгээ зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Найрамдал, Онги-Өргөө сууц өмчлөгчдийн холбооны үйлчилгээний ажилтнуудад урамшуулал олгох зардалд 1,220,000 (Нэг сая хоёр зуун хорин мянга) төгрөгийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2. Дээрх зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Ж.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ГАНБАТ